

БАТЛАВ. ҮНДЭСНИЙ БӨХИЙН МЭРГЭЖЛИЙН ЛИГИЙН ЗӨВЛӨЛ

ҮНДЭСНИЙ БӨХИЙН МЭРГЭЖЛИЙН ЛИГИЙН ЧАНСАА ТООЦОХ ЖУРАМ

Үндэслэл. Энэхүү Чансаа тооцох журмыг "Хил хязгааргүй спорт" ТББ-ын эзэмшиж буй Оюуны өмчийг ашиглах эрхтэй Үндэсний бөхийн лигийн цуврал барилдаанд оролцогч бөхчүүдийн чансаа тооцох системийн дагуу боловсруулсан болно.

1. Лигийн барилдааныг 3 зэрэглэлд ангилна. Зэрэглэлийг тодорхойлох үндсэн үзүүлэлт нь шагналын сангийн хэмжээ байна.
 - А зэрэглэл. Шагналын сан: 10 сая төгрөгөөс доошгүй
 - В зэрэглэл. Шагналын сан: 7 сая төгрөгөөс доошгүй
 - С зэрэглэл. Шагналын сан: 5 сая төгрөгөөс доошгүй

Жич: Анхдугаар барилдаан шагналын сангийн хэмжээнээс үл хамаарч "А" зэрэглэлд хамаарна.

2. "Оны тэргүүн бөх" буюу шигшээ барилдааныг "А" зэрэглэлийн барилдаантай адилтгаж, чансааны оноо тооцно. "Оны тэргүүн бөх" шалгаруулах барилдааны Шагналын санг тусгайлан зарлана. Оны шигшээ барилдаанд чансааны эхний 16 бөх оролцох эрхтэй.
3. Чансааг 7 хоногийн даваа гариг бүр шинэчлэн зарлана.
4. Аливаа барилдаанаас авсан чансааны оноо 52 долоо хоногийн дараа хуучирч чансаа тооцохоос хасагдана.
5. Дор дурдсан нөхцөлийг хангаагүй бол бөх чансааны жагсаалтад бичигдэхгүй, өөрөөр хэлбэл чансаа тооцогдохгүй:
 - Тухайн жилдээ хамгийн багадаа нийт 12 удаагийн барилдаанд барилдсан байх
 - В зэрэглэлийн барилдаанд хамгийн багадаа 8 удаа барилдсан байх
 - тухайн бөхийн С зэрэглэлийн барилдааны шилдэг 5 үзүүлэлтийг оруулах
 - Чансаанд тооцогдсон аливаа барилдааны дүнг 52 долоо хоногоос илүү хугацаанд тооцохгүй, өөрөөр хэлбэл уг баоилдааны дүн чансааны онооноос хасагдана.
 - Нэг сараас дээш эмчийн магадлагаагаар өвчтэй байсан тохиолдолд
6. Дээрх 5 дугаар заалтыг 2022 оны барилдаануудаас эхлэн мөрдөнө.
7. Энэхүү журманд Мэргэжлийн зөвлөлийн саналыг харгалзан баталсан 3 талын нэгдсэн шийдвэрээр өөрчлөлт оруулна.
8. Чансаа доорх хүснэгтэнд үзүүлснээр тооцно. Лигийн албан ёсны вэбсайтад өөрчлөлт орсон даруйд нийтэлнэ.

Чансааны онооны хүснэгт

Барилдааны ангилал	Түрүү	Үзүүр	Шөвгийн 4	Шөвгийн 8	Шөвгийн 16	32	64	128
A	1500	900	500	250	150	70	30	10
B	1000	750	400	200	100	50	25	10
C	750	450	300	150	70	30	15	5

ХИЛ ХЯЗГААРГҮЙ СПОРТ ТББ
2021 он